



## ЗАСГИЙН ГАЗРЫН ШИНЭЧЛЭЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО<sup>4</sup>

**Ж.БОЛДБААТАР**

*ХСИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
доктор, профессор, цагдаагийн хурандаа*

Эрхэм хүндэт эрдэмтэн, судлаач, багш Та бүхэнд Шинжлэх ухааны ажилтны өдрийн баярын мэнд хүргэе!

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн дагуу Хууль сахиулахын их сургуулийн бүтцэд Эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулагдсан билээ.

ЭШХ-ийн эрхэм зорилго нь Монгол Улсын хууль сахиулах салбар, Хууль сахиулахын их сургуулийн бодлого, үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлээр хангах, судалгаа, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд оршино.

Уг зорилгын хүрээнд улсын дотоод аюулгүй байдлыг хангах бодлого, хууль сахиулах үйл ажиллагааны стратегийн үндсэн асуудлаар судалгаа хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй тайлан, зөвлөмж боловсруулах, дотоод аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах субъектүүдийн хүрээнд онол, практикийн судалгаа явуулж, тэдгээрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар онол, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

ЭШХ нь Цагдаа судлал, Хил судлал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, Шүүх шинжилгээ, гамшгийн эрсдэл судлал, Инновацийн төв гэсэн 5 төвтэй үйл ажиллагаа явуулдаг.

ЭШХ-ийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд нэр хүндтэй эрдэмтэд, чадварлаг залуу судлаачдаар боловсон хүчнээ бүрдүүлж, тэднийг орчин үеийн өндөр чадал бүхий техник хэрэгслээр хангах, мөн нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, ажиллах нөхцөл, орчныг сайжруулах талаар тодорхой ажлыг ХЗЯ, ЦЕГ, ХХЕГ, ШШГЕГ, ОБЕГ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна.

Хүрээлэн үндэсний аюулгүй байдлыг баталгаатай хангах хүрээнд цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, шүүх шинжилгээ болон гамшгийн эрсдэл судлалын чиглэлээр хөгжлийн тулгамдсан асуудлыг судлан, шийдвэрлэх арга замыг тодорхойлох үүрэг бүхий салбарын эрдэм шинжилгээний байгууллага бөгөөд цаашид цар хүрээгээ өргөжүүлэхээр ажиллаж байна.

Хүрээлэнгээс эрдэм шинжилгээ, судалгааны дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

### **Үүнд:**

1. Үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд хүрээлэнгийн дүрэм, бүтэц, орон тоог Хууль сахиулахын их сургуулийн Эрдмийн зөвлөлөөр батлуулав.

<sup>4</sup> Хууль сахиулах их сургууль дээр 2012.11.23-ны өдөр зохион байгуулагдсан "Шинжлэх ухааны ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүндэтгэлийн баярын хурал" дээр ХСИС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, цагдаагийн хурандаа Ж.Болдбаатарын тавьсан илтгэл



Их сургуулийн болон хүрээлэнгийн дүрэм, заавар, дотоод журам боловсруулах ажилд голлох үүрэгтэй оролцож, эрдэм шинжилгээний ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ зэрэг баримт бичиг боловсруулан мөрдөж байна.

2. “Зэвсэгт хүчин ба хил хамгаалах байгууллагын уялдаа холбоо, бүтэц”, “Хилийн боомтын бүтэц, удирдлага, хамрах хүрээ, чиг үүргийн хэтийн төлөв” сэдэвт судалгаа явуулж, тайланг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

3. “Төрийн эрүүгийн бодлогын онол, практикийн тулгамдсан асуудал”, “Цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох”, “Цагдаагийн байгууллагын техник хэрэгслийн хангалтын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”, “Хэсгийн байцаагчийн үйл ажиллаганы эрх зүйн орчин, ажиллах нөхцөл”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин”, “Монгол Улсад мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага”, “Бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн төрөл, шалтгаан, нөхцөл”, “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны ил тод байх зарчим”, “Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шатанд прокурор, цагдаа, гааль, тагнуулын байгууллагын харилцан уялдаа, түүний онцлог”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох” зэрэг 10 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж, судалгааны тайлан, зөвлөмж боловсрууллаа.

4. ЭШХ-ээс санаачлан 2012 оны 6, 9 дүгээр сард “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал”, “Хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2 удаа амжилттай зохион байгуулж, зөвлөмж гарган холбогдох байгууллагад хүргүүлэв.

Эдгээр олон улсын хуралд хэд хэдэн улсын төлөөлөл хүрэлцэн ирсний дээр төрийн байгууллагууд, дипломат корпус, их, дээд сургууль, иргэний нийгмийн өргөн төлөөлөл оролцсоноороо ихээхэн ач холбогдолтой болсныг тэмдэглэхийг хүсч байна.

5. ЭШХ-ээс эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хэд хэдэн гадаад арга хэмжээнд хамрагдлаа. Тухайлбал, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 6 ажилтан ОХУ, БНХАУ, АНУ, Польш, Герман улсад эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, туршлага судлах, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцохоор зорчсон болно.

Түүнчлэн, АНУ-ын Криминологичдын Холбооны Ерөнхийлөгч Крисс Эскридж, Английн цагдаагийн ажилтан Кристиан Эллисийг хүрээлэнд урьж, хамтын ажиллагаа эхлүүлсэн зэргээр хүрээлэнгийн гадаад харилцаа өдрөөс өдөрт өргөжин тэлсээр байна.

6. Хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид өнгөрсөн хугацаанд нийт 8 сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл хэвлүүлжээ.

Мөн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид “Гэмт явдалтай тэмцэх асуудал”, “Үндэсний тойм”, “Хууль дээдлэх ёс”, “Шударга ёсны хэмжүүр”, “Шүүхийн



шийдвэр гүйцэтгэл судлал”, “Хил судлал”, “Цагдаа судлал” зэрэг сэтгүүлд **20** гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл хэвлүүлэн нийтийн хүртээл болгосноос гадна, олон улсын болон улсын хэмжээний эрдэм шинжилгээний хуралд **10** илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

7. Тус хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид магистрант, докторант нарт хичээл заах, эрдэм судлалын чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ 2012 онд **6** доктор, **20** магистр, **5** бакалаврын судалгааны ажлын удирдагчаар ажиллан, амжилттай хамгаалуулжээ.

8. Их сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг бодлогын түвшинд нэгтгэн зангидах, үр дүнг үнэлэх үүднээс багш нарын эрдэм шинжилгээний ажлын багц цагийг тооцож, багш, суралцагч нарыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд татан оролцуулж, багш, суралцагч бүр судлаач байхыг эрхэмлэн, ажил хэрэг болгож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй эрх зүйн шинэтгэл, хууль зүйн салбарын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд Хууль сахиулах их сургууль, түүний эрдэм шинжилгээний ажилтан, багш нар голлох байр суурьтай оролцох нь дамжиггүй.

Хууль зүйн салбарын шинэчлэлтэй уялдуулан **Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс:**

- Шинэтгэлийн хүрээнд хийж буй хуулийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах, уг ажилд эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээр дэмжлэг үзүүлэх;
- Хууль сахиулахын их сургууль болон хууль сахиулах байгууллагын тулгамдсан асуудлыг шийдэх гарцыг эрэлхийлж олдог, хариуцсан салбартаа сургалтаар тэргүүлэх их сургууль болох зорилтыг шийдвэрлэхэд эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар дэмжлэг үзүүлэх;
- Хууль сахиулахын их сургуулийг жишиг цахим их сургууль болоход арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- Гадаадын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын шинэ арга, аргачлал, техник, технологийн сайн, тэргүүн туршлага судлан, нутагшуулах;
- Хүний үнэн худал хэлснийг тодорхойлох полиграф төхөөрөмжийг практик, сургалтад нэвтрүүлэх, полиграфын стандарт, хэрэглэх зөвлөмж боловсруулах, полиграфын оператор бэлтгэх сургалт зохион байгуулах;
- Монгол Улсад гэмт хэргийн цахим зураглалын систем (crime mapping) нэвтрүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах, түүнчлэн кибер гэмт хэргийн талаар судалгаа явуулан, мэдээллийн аюулгүй байдлын цогц бодлого боловсруулах;
- Төрийн эрүүгийн бодлогын онол, практикийн тулгамдсан асуудлаар хийсэн суурь судалгааны үр дүнгээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын олон талт үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэх, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй



болгохтой холбогдсон судалгааны ажил явуулж, үр дүнг тайлагнах;

- Улсын хилийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын хилийн тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгийг шинээр боловсруулахад голлох үүрэг гүйцэтгэх;
- Шүүх шинжилгээний чиглэлээр шинжилгээний шинэ техник, технологи нэвтрүүлэх;
- Инновацийн төвийг шинээр эмхлэн байгуулж, түүнд ажиллах боловсон хүчин, ашиглах техник хэрэгслээр хангаж, түүнд түшиглэн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, туршилтын орчин үеийн Лаборатори байгуулах (teizer буу, электрон гав, профайлинг гэх мэт), үүнд шинэ техник, технологи, аргачлал, стандартыг сургалт болон практикт нэвтрүүлэх зэрэг болно.

Эрхэм хүндэт эрдэмтэн, судлаач Та бүхэнд гүн талархал илэрхийлье!

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН